



84

# МОНГОЛ УЛС ШАДАР САЙДЫН ТУШААЛ

20 19 оны 04 дугаар  
сарын 24 -ны өдөр

Дугаар 30

Улаанбаатар  
хот

Стандартчилал, тохирлын үнэлгээний  
ажил үйлчилгээний төлбөрийн  
хэмжээг тогтоох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1, 30 дугаар зүйлийн 30.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Стандарт, хэмжил зүйн газрын Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний төлбөрт ажил үйлчилгээний төлбөрийн хэмжээг олон улс, бүс нутаг, гадаад орны стандартчиллын байгууллагын стандартын төлбөрийг нэгдүгээр, Үндэсний стандартын үнийг хоёрдугаар, Стандартын мэдээлэл, лавлагааны бусад ажил үйлчилгээний төлбөрийн хэмжээг гуравдугаар, Стандартын тооноос хамаарах төлбөрийн хөнгөлөлтийг дөрөвдүгээр, Аж ахуйн нэгж, байгууллагуудын боловсон хүчинд мэдлэг чадвар эзэмшүүлэх сургалтын төлбөрийг тавдугаар, Хичээл заасан багшийн ажлын хөлсийг зургадугаар, Олон улсын стандарт, баримт бичиг орчуулах ба хянах ажлын хөлсийг долдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2. Энэхүү тушаалыг 2019 оны 5 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтийг хангах, олон улсын стандарт, баримт бичиг орчуулах, хянах ажлын хөлс болон хичээл заасан багшийн ажлын хөлсийг жил бүрийн улсын төсөвт тусгаж санхүүжүүлэх, зардлын гүйцэтгэлийг улирал тутам гарган төсвийн зарцуулалтад хяналт тавьж ажиллахыг Стандарт, хэмжил зүйн газар /Б.Билгүүн/-т даалгасугай.


Монгол Улсын Шадар сайд



Ө.ЭНХТҮВШИН

0000030





СУРГАЛТЫН ТӨЛБӨРИЙН ХЭМЖЭЭ

Д/д	Сургалтын багц	Нэг хүний сургалтын төлбөр, төгрөг	Тайлбар
0	1	2	3
1	Нэг модульт сургалт /M1/	60,000	1 өдрийн сургалт
2		90,000	2 өдрийн сургалт
3	Олон модульт сургалт /M1, M2 . . . /	120,000	3-аас дээш өдрийн сургалт
4	Эрх олгох болон аттестатчилах сургалт /онолын хичээл, дадлага, шалгалт/	150,000	5-10 өдрийн сургалт
		250,000	14-45 өдрийн сургалт

Тайлбар:

- Сургалтын 1 цагийг хичээлийн 45 минутаар тооцно.
- Энэхүү сургалтын төлбөрийн хэмжээг аж ахуйн нэгж, байгууллагын захиалгаар зохион байгуулах сургалтын гэрээнд төлбөрийн жишиг болгон ажиглаж болно.